

НИЙСЛЭЛИЙН АГААРЫН БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН 2020 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЙЛАН

Байгууллагын хэмжээнд 2020 оны 03 дугаар улирлын байдлаар нийт 18 өргөдөл, гомдол ирснээс хугацаандаа шийдвэрлэж хариу өгсөн 12, хугацаа хэтэрч шийдвэрлэгдсэн 2, судлагдаж байгаа 4 өргөдөл, гомдол байна. Захиргааны хэлтэст 4, Бодлогын хэрэгжилтийн хэлтэст 9, Агаарын чанар, хяналт, зохион байгуулалтын хэлтэст 5 өргөдөл, гомдол цохогдсон байна. Өргөдлүүдийн дамжин ирсэн эх үүсвэрүүд НҮНТ- 4 бүртгэсэн ,ННЗБ бүртгэсэн 8, 1800-1200 дугаараас ирсэн 4, 11-11 төвөөс ирсэн 1, E-Service 1 нийт өргөдөл, гомдол 18 ирсэн байна. Мөн байгууллагад цаасаар ирсэн өргөдөл, гомдлыг скайнердаж ep.ulaanbaatar.mn-д оруулан байгууллагын удирдлагад шилжүүлэн ажиллаж байна.

Ирсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг хугацаагаар нь авч үзвэл 5 хоногт багтаан шийдвэрлэсэн 5, 10 хоногт багтаан шийдвэрлэсэн 3, 15 хоногт багтаан шийдвэрлэсэн 2, 30 хоногт багтаан шийдвэрлэсэн 3, хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 12 өргөдөл байна. 2020 оны 03 дугаар улирлын өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 14 хоног 7 цаг 57 минут байна.

Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл, гомдлыг авч үзвэл АЧХЗБХ-ийн мэргэжилтэн Э.Энх-Амгалан 1 өргөдөл, БХХ-ийн мэргэжилтэн Э.Батцэцэг 1 өргөдөл, хугацаа хэтэрч шийдвэрлэсэн байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээг хүснэгтэд харуулав.

Хүснэгт 1. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн байдал /Хэлтэс тус бүрээр/

| Нэгж/хэлтэс | Хугацаандаа шийдвэрлэсэн | Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн | Шийдвэрлэх хугацаандаа байгаа |
|---|--------------------------|-----------------------------|-------------------------------|
| Захиргааны хэлтэс | 4 | - | 1 |
| Бодлогын хэрэгжилтийн хэлтэс | 9 | 1 | 1 |
| Агаарын чанар, хяналт, зохион байгуулалтын хэлтэс | 5 | 1 | 1 |
| Нийт | 18 | 2 | 3 |

03 дугаар улирлын байдлаар өргөдөл, гомдлын хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн, өргөдөл гомдлыг өдөрт нь хүлээж аваагүй, явцын тэмдэглэл хөтлөөгүй зөрчлүүд их байна. Өргөдөл гомдлын хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн мэргэжилтэн, өргөдөл гомдол шийдвэрлэлтийн явцад хяналт тавьж ажиллаагүй Архив, бичиг хэргийн ажилтан нарт дахин зөрчил гаргахгүй байхыг газрын удирдлагаас сануулга өгсөн. Өргөдөл гомдлын хандлага ихсэх төлөвтэй байгаа тул анхааран зөрчлийн тоон үзүүлэлт дээр анхааран ажиллах болно.

ХЯНАСАН: ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ,
ХАМТЫН АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Э.ЭНХМАА

ТАЙЛАН ГАРГАСАН: АРХИВ, БИЧИГ
ХЭРГИЙН ЭРХЛЭГЧ

Э.БЯМБАЦЭЦЭГ